

## Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

## Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар

2023 оны X сар

Шийдвэрийн д/д	Заалтын д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ
ЗГ-ын тогтоол						
1	1	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	<p>5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай:</p> <p>5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх;</p> <p>5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх;</p> <p>5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших;</p> <p>5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх;</p> <p>5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.</p>	<p>Аймгийн Хэлний бодлогын салбар зөвлөлөөс аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллага, хөдөөгийн 14 сумын нийт 37 удирдлагад төрийн албан хаагчдын үндэсний бичгийн сургалтыг эрчимжүүлэх чиглэл өгсний үр дүнд аймгийн нийт 3270 төрийн албан хаагчдын 66 хувь буюу 2158 төрийн албан хаагчид 2022-2023 онд сургалтад хамрагдсан дүн мэдээтэй байна. Аймгийн Боловсрол шинжлэх ухааны газраас ажлын 3 хэсэг гарч хөдөөгийн 14 сумын хэлний бодлогын салбар зөвлөлийн ажилтай удирдамжийн дагуу танилцан, зөвлөн туслах ажлыг зохион байгуулж чиглэл өгөв. Аймгийн хэмжээнд төрийн байгууллагын гадна хаягийг үндэсний бичиг болгох удирдамж чиглэлийг 2021-2023 онуудад төрийн байгууллагууд чиглэл өгч аймгийн 155 байгууллагуудын хаягжилтын судалгааг 11 сард авахаар ажиллаж байна. Хүмүүн бичиг сониныг захиалах ажлыг эрчимжүүлж, аймгийн Засаг даргын захирамж гарган хэрэгжүүлж, байгууллагуудын захиалсан дүн мэдээг 11 сард нэгтгэн мэдээлэхээр болов.</p> <p>Хэрэгжилтийн явц: Тодорхой ахиц гарсан</p>	70%	

2	2	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-25 Дугаар 2022_204	3. Дуудлагын автомашины зориулалтаар хуваарилан шилжүүлснээс бусад автомашиныг төрийн холбогдох байгууллагын зайлшгүй шаардлага, хэрэгцээг харгалзан эрэмбэлсний үндсэн дээр зарим хэсгийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.5-д заасан байгууллагад албан ажлын зориулалтаар хуваарилах, үлдэх хэсгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулж, орлогыг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 4 автомашины худалдах доод үнийг шинэчлэн тогтоолгохоор холбогдох материалыг хүргүүлсэн. Аймгийн иргэдийн төлөөлөгчийн хуралдахыг хүлээж байна.  Хэрэгжилтийн явц: Тодорхой ахиц гарсан	Х.Б	
3	3	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл, арга хэмжээг батлах тухай 2022-08-24 Дугаар 2022_314	2. “Төрөөс дэмжлэг үзүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл (2022-2027)”-ийг 1 дүгээр хавсралт, “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ (2022-2030 он)”-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай. 2. Энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралтад заасны дагуу соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж, шаардагдах хөрөнгийг улсын төсөв, гадаадын болон олон улсын байгууллага, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Соёлын сайд Ч.Номин, Сангийн сайд Б.Жавхлан нарт, салбарын болон аймаг, нийслэлийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган төрийн бус, хувийн хэвшил, хэвлэл мэдээлэл, эрдэм шинжилгээний холбогдох байгууллагууд болон иргэдийг татан оролцуулж, батлагдсан төсвийн багцын дүнд багтаан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг холбогдох Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Дундговь аймгийн музейгээс “Зүү ороох”, “Утас ээрэх”, сургалтыг 10 дугаар сарын 25-аас эхлэн 1 сарын аян зарлан аймгийн төвийн ЕБС-ийн хүүхдүүдийн дунд зохион байгуулж байна. Энэ удаагийн сургалтад Хүмүүнлэг сургуулийн Б.Үенч багштай охидын дугуйлангийн 6-10-р ангийн 9 сурагчид хамрагдаж Сургагч багшаар музейн үйлчилгээний ажилтан Д.Хоролсүрэн ажиллаж байна. Дундговь аймгийн Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театр нь: Улсын Хүүхэлдэйн театрын найруулсан “Миний хөөрхөн шүдний аялал” жүжгийн зохиолыг фрайнчайзингаар авч өөрсдийн уран бүтээлчдийг тоглуулан аймгийн Өлзийт, Сайхан-Овоо, Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Адаацаг зэрэг баруун бүсийн сумдаар аялан тоглолт хийн хөдөөгийн 500 гаруй хүүхдэд хүрч үйлчилсэн байна. Өлзийт сумын Соёлын төв нь: Хичээлийн шинэ жилээс эхлэн өнөөг хүртэл сургуулийн хүүхдүүдийн дунд үндэсний хөгжим болон морин хуурын дугуйланг үнэ төлбөргүйгээр зохион байгуулан ажиллаж байна. Үүнд: Үндэсний хөгжим 14, Морин хуурын үндсэн дугуйланд 30, цагийн сургалтад 36 хүүхэд	70%	

				нийт 80 гаруй сурагчид хамрагдаад байна.Хэрэгжилтийн явц: Тодорхой ахиц гарсан		
4	4	Орон сууцны хороолол, цогцолбор барилгад хүүхдийн	1.3. цэцэрлэгийн барилга төлөвлөөгүй орон сууцны хороолол, цогцолбор барилгын зураг төслийг баталж магадлан хийсэн, барилгын ажлын зөвшөөрөл олгосон, хүлээн авч ашиглалтад оруулсан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулах талаар зохих арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	2023 оны 10 дугаар сарын байдлаар цэцэрлэгийн барилга төлөвлөөгүй орон сууцны хороолол, цогцолбор барилгын зураг төслийг баталж магадлан хийсэн, барилгын ажлын зөвшөөрөл олгосон, ашиглалтад оруулсан барилга байхгүй болно  Хэрэгжилтийн явц: Ажил огт хийгдээгүй	Х.Б	
	5	цэцэрлэг байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-09 Дугаар 2022_402	1.4. орон сууцны хороолол, цогцолбор барилгын 1, 2 дугаар давхарт цэцэрлэг байгуулах зорилгоор түрээслэх, худалдан авах, салбар бүлэг ажиллуулахад норм нормативыг мөрдүүлэх чиглэлээр мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг авч, хэрэгжилтийг хангаж, хамтран ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Орон сууцны хороолол, цогцолбор барилгын 1, 2 дугаар давхарт баригдахаар төлөвлөгдсөн цэцэрлэг байхгүй болно.  Хэрэгжилтийн явц: Ажил огт хийгдээгүй	Х.Б	

	6		<p>2. Цаашид шинээр баригдах орон сууцны хороолол, цогцолбор барилга байгууламжийн зураг төсөлд цэцэрлэг төлөвлөх, ашиглалтад оруулах талаар дараах арга хэмжээ авч хэрэгжилтийг хангаж ажиллахыг дор дурдсан холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай: 2.1. барилга байгууламжийн газар олголт, барилгажилтын төсөл, архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг төсөлд холбогдох норм, дүрмийн дагуу цэцэрлэгийн барилгыг заавал тусган баталгаажуулж байхад хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 2.2. орон сууцны хороолол, цогцолбор барилгад төлөвлөгдсөн цэцэрлэгийн барилгыг бүрэн ашиглалтад орох хүртэл хугацаанд тухайн бүс нутгийн байршилд “түр цэцэрлэг” байгуулан ажиллуулж байх талаар хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.</p>	<p>Сайнцагаан сумын 7 дугаар багт байршилтай “Түмний хороолол”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөлд 150 ортой цэцэрлэгийн барилга төлөвлүүлэн загвар зургийг баталсан.Хэрэгжилтийн явц: Тодорхой ахиц гарсан</p>	70%	
	7		<p>3. Хот, тосгоны хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд хот байгуулалтын норм, дүрмийн шаардлагыг хангасан цэцэрлэгийн барилгыг тусгасан эсэхэд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.</p>	<p>Сумдын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулан батлуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа бөгөөд 2023 онд боловсруулсан Эрдэнэдалай, Цагаандэлгэр сумдын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд норм дүрмийн дагуу цэцэрлэгийн барилгыг төлөвлүүлсэн. Ингэснээр 13 сумын ерөнхий төлөвлөгөөнд тусган ажиллаад байна.</p> <p>Хэрэгжилтийн явц: Тодорхой ахиц гарсан</p>	70%	
5	8	<p>Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай</p>	<p>3. Энэ тогтоолын 2-т заасан чиглэлийн хүрээнд орон нутгийн хэмжээнд Ажлын хэсэг байгуулж, тодорхой арга хэмжээ авч, шаардагдах эх үүсвэрийг батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. /2. Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл</p>	<p>Хот хөдөөгийн сэргэлтийн дэд ажлын хэсгийг байгуулж үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, Орон нутгийн төсөвт 800.0 сая төгрөг тусгуулсан. Тус батлагдсан төсөвтэй ажлуудаас Малчны хөгжлийг дэмжих төвийн ТЭЗҮ боловсруулах 200,0 сая, Хаус, түмний хорооллын ерөнхий төлөвлөгөө боловсруулах 100.0 сая төгрөгийн</p>	70%	

		2022-11-23 Дугаар 2022_419	боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгох арга хэмжээний цогц хөтөлбөр боловсруулж, батлуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт тус тус үүрэг болгосугай./	гэрээ хийгдэж, ажлын хэсгийн үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалтын чуулга уулзалт бусад орон нутаг сурталчлах бичлэг, контент хийхэд 118 сая төгрөг зарцуулаад байна.  Хэрэгжилтийн явц: Тодорхой ахиц гарсан		
	9		4. Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой тэнцвэрийг хангах зорилгоор Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ аймаг, нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг хүн амынхаа тоог 20 хувиар, бусад аймаг 10 хувиар тус тус нэмэгдүүлэх бодлогын чиглэлийг баримталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн болон нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	2023 оны 10 сард Улаанбаатар хотоос 18 иргэн шилжиж ирснээс насанд хүрэгчид 8 иргэн, хүүхэд 10 өөр аймгаас нийт 6 иргэн насанд хүрэгчид 2 хүүхэд 4, шилжин ирж суурьшсан байна.Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаасХэрэгжилтийн явц: Тодорхой ахиц гарсан	30%	
6	10	Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-12-07 Дугаар 2022_448	1.12. . 1.12 гүйцэтгэсэн ажлын бүтээмжийг нь харгалзан аймаг, сумын засаг захиргааны байгууллагад ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын үндсэн цалинг хоёр дахин хүртэл нэмэгдүүлсэн хэмжээгээр тооцож, орон нутгийн нэмэгдлийг батлагдсан төсөвтөө багтаан олгох арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;  1.13.орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавихад холбогдох хууль тогтоомжийг баримталж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Аймгийн засаг даргын 2023.01.16-ны өдрийн А/17 тоот захирамжаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа орон нутгийн төсвийн байгууллагын төрийн захиргааны албан хаагчдад ажлын ачаалал, ажил үүргийн хариуцлагыг харгалзан 10-30 хүртэл хувиар орон нутгийн нэмэгдлийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн төсөвтөө багтаан олгож хэрэгжүүлэн мөрдөн ажиллаж байна. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжиж буй 37 төсөл арга хэмжээний гэрээг байгуулсан. 2023 онд нийт 18 тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-тай нийгмийн хариуцлагын гурвалсан гэрээг хийсэн бөгөөд нийт 800 сая төгрөг ОНХС-д орохоор төлөвлөн	100%	

		<p>1.14.ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээний хүрээнд нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламжийг аймаг болон сумын орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж, орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрт хууль тогтоомжид нийцүүлэн зарцуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;</p> <p>1.15.нийслэлээс орон нутагт шилжин суурьшсан иргэнд жилийн 3 хувийн хүүтэй ипотекийн зээл олгох, орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжийн арилжааны банкнаас авсан зээлийн хүүг 1 хувь хүртэл бууруулж олгох ажилд орон нутгийн зүгээс шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;</p> <p>1.16.нийслэлээс орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжид бизнесээ эрхлэхэд нь зориулж газар болон холбогдох тусгай зөвшөөрөл олгох арга хэмжээг хүнд сурталгүйгээр шуурхай шийдвэрлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;</p> <p>1.17.гадаад зээлийн хөрөнгөөр орон нутагт хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хүрээнд эргэн төлөгдөх нөхцөлтэй дамжуулан зээлдүүлэх гэрээгээр олгосон зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг Монгол Улсын 2023 оны төсөвт тусгасан дүнгээр бүрэн төлж барагдуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;</p>	<p>хэрэгжүүлж байна. Нийслэлээс орон нутагт шилжин суурьшсан иргэнд ипотекийн 3 хувийн зээл 4 сараас олгогдож эхэлсэн бөгөөд иргэд мэдээлэл авч зээл авах хүсэлт нэмэгдсэн байна. Дэд ажлын хэсгийн хүрээнд нийслэлээс орон нутагт шилжин ирж буй иргэд, ААН-д газар олгох болон бусад үйлчилгээг хуулийн дагуу түргэн шуурхай үйлчлэхийг холбогдох ажилтнуудад удаа дараа үүрэг болгон ажиллаж байна. Гадаад зээлийн хөрөнгөөр орон нутагт хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хүрээнд эргэн төлөгдөх нөхцөлтэй дамжуулан зээлдүүлэх гэрээгээр 2 төслийг 2023 оны төсөвт үндсэн болон хүүгийн төлбөрт нийт 1940563,4 мянган төгрөг тусгаж батлагдсан хуваарийн дагуу төлж барагдуулахаар ажиллаж байна.</p> <p>Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн</p>		
11		<p>2. Төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай: 2.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг</p>	<p>2.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг аймгийн 2023 оны ОНХС-д 200,0 сая төгрөг батлан хэрэгжүүлж байна. тус батлагдсан зардлын үр дүнд 2024 онд аймгийн болон</p>	100%	

			<p>санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах; 2.2.төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх; 2.3.төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, батлагдсан санхүүжилтийг төсвийн жилд багтаан бүрэн олгох арга хэмжээг авах; 2.4.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд барилгын материалын үнийн өсөлтийн нэмэгдэл нь батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтийг санхүүжүүлэхэд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний бэлтгэл ажил, зохион байгуулалтыг шуурхай зохион байгуулах; 2.5.Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагааг Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS-www.publicinvestment.gov.mn)-ээр дамжуулан хэрэгжүүлж ил тод, нээлттэй байдлыг хангах.</p>	<p>сумын ОНХС,УТХО-аар хэрэгжүүлэх 15 зураг төсвийг боловсруулахаар гэрээ хийж 10 зураг төсөв хүлээж аваад байна.2.2 10 дугаар сард худалдан авах ажиллагааны үр дүнд 180.2 сая төгрөгийн хэмнэлт үүсэн бөгөөд тус хэмнэлтийг зарцуулаагүй.2.3 ОНХС-ын хөрөнгө оруулалтаар батлагдсан 42 төсөл арга хэмжээнээс 38 төсөл арга хэмжээний гэрээг байгуулсан.ОНХО-аар батлагдсан 32 төсөл арга хэмжээнээс 28 төсөл арга хэмжээний гэрээг байгуулаад байна. Дээрх ажлуудыг журмын дагуу хянаж санхүүжүүлж байна.2.4 2024 оны УТХО-д үнийн өсөлт нь батлагдсан 3 төсөл арга хэмжээний үнийн өсөлтийн зөрүүг олгоод байна.2.5 Шинэ хөдөө төслийн дундын санхүүжилт 61.0 сая, 2-р цэцэрлэгийн дундын санхүүжилт 118.0 сая төгрөгийн санхүүжилтийг Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS-www.publicinvestment.gov.mn)-ээр дамжуулан олгоод байна.Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн</p>	
7	12	<p>Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2022-12-28 Дугаар 2022_488</p>	<p>5. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.</p>	<p>Аймгийн засаг даргын 2023,01,16-ны өдрийн А/18 тоот захирамжаар Үйлчилгээний албан хаагчдын орон нутагт ажиллах сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн төсвөөс санхүүждэг төсвийн байгууллагын төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээг 5 хувиар нэмэгдүүлэн 2023 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн 07-р сарын 31 хүртэл төсөвтөө багтаан олгож хэрэгжүүлэн мөрдөн ажиллаж байна.</p> <p>Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн</p>	100%

8	13	Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай 2023-01-11 Дугаар 2023_79	3. Хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг 2023 оны батлагдсан төсөвтөө багтаан, шаардлагатай бол зохицуулалт хийн санхүүжүүлж, цаашид холбогдох эх үүсвэрийг жил бүрийн улсын төсвийн төсөлд батлуулж байхыг Засгийн газрын холбогдох гишүүд, Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	3, Аймгийн засаг даргын тамгын газарт Геологи, уул уурхай, газрын тос, хийн хяналтын ахлах байцаагч, Эрчим хүчний хяналтын улсын байцаагч хяналт шалгалтын үйл ажиллагааг явуулж байна. Хяналт шалгалтыг зохион байгуулахад шаардагдах 4,978,500 төгрөгийг Сангийн сайдын 134-р тушаалын дагуу санхүүжүүлсэн.  Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн	100%
9	14	Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_55	1. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлийн явцтай уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын тухайн онд батлагдсан дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийж, санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай	1. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан улсын төсвийн нийт 32 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлийн явцтай уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын тухайн онд батлагдсан дүнд багтаан санхүүжүүлж байна. Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн	100%
10	15	Хүнсний хангамж, хөдөө аж ахуйн салбарын технологит ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_63	3. Мал, малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох зорилгоор нийт үхэр сүргийг ялган тэмдэглэж, Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Улсын хэмжээнд хийх ажил болгон зарласан боловч төсөв хөрөнгийн асуудлаас болж Монгол улсын хил орчмын аймгууд болон төвийн бүсийн зарим сумдад хийгдэхээр болсон. Тус аймагт хамааралгүй тул хасуулах саналтай байна.  Хэрэгжилтийн явц: Ажил огт хийгдээгүй	Х.Б
11	16	Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_68	7. Шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх цахим платформыг үүсгэн, төрийн үйлчилгээг цахимжуулан “Цахим аймаг” болгох арга хэмжээ авч ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны яам (Н.Учрал), аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	Шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх huduu.mn цахим платформд Дундговь аймгийн мэдээллийг тухай бүр нь байршуулж байна. Аймгийн төвд төрийн цахим үйлчилгээний “ХУРДАН” гурван цэгийг байгуулж, компьютер техник хэрэгсэл, тавилга тоног төхөөрөмжөөр ханган ажиллаж байна. 10 сарын байдлаар 530 төрлийн цахим үйлчилгээг иргэдэд хүргэж ажиллаж байна.	100%



				Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн		
12	17	Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай 2023-04-05 Дугаар 2023_119	2. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн хэлбэрээр хаах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, мөнгөн төлбөрийг төвлөрүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	2023 оны II ээлжийн цэрэг татлагаар 29 хүнд цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэмжээгээр орлуулан хаалгахаар ЦШ-ын мэдэгдэх хуудас олгосон. 2023.11.03-ны байдлаар төрийн сан дахь Цэргийн штабын дансанд 27.220.000 төгрөг төвлөрсөн байна.  Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн	100%	

13	18	Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2023-04-05 Дугаар 2023_120	2.3. “Хот хөдөөгийн сэргэлт”-ийн хүрээнд нийгэм, эдийн засгийн бүсчлэл тогтоох схем, арга зүй, шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох, эдийн засгийн өсөлтийн төв боомтуудын тусгайлсан орон зайн хөгжлийн төлөвлөлтийг боловсруулж, дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн дарга нарт;	“Хот хөдөөгийн сэргэлт”-ийн хүрээнд нийгэм, эдийн засгийн бүсчлэл тогтоох схем, арга зүй, шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох, орон зайн хөгжлийн төлөвлөлтийн дагуу Дундговь аймгийн Өлзийт сумын нутаг дэвсгэрт орших Цагаан суварга орчимд Үлэг гүрвэлийн палентлогийн төв байгуулах ТЭЗҮ- боловсруулах 800 сая төгрөгийн төсвийг Эдийн Засаг хөгжлийн яамны зураг төсөв ТЭЗҮ боловсруулах зардалд тусгуулсан. Тус ажлын гүйцэтгэгчээр ЛАНД ОВНЕР ХХК шалгарч гэрээ байгуулсан бөгөөд Палеонтологийн нөөцөд тулгуурлан “Аялал – Судалгаа Амралтын цогцолбор” байгуулах ажлын техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв хийж гүйцэтгэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг энэ сарын 25-ны өдөр хүлээн авч уулзан, санал солилцлоо. Ажлын хэсгийн гишүүд, орон нутгийн мэргэжлийн байгууллагуудын төлөөлөл хамтран уулзалтын дараагаар Өлзийт сумын нутаг Цагаан суварга байгалийн цогцолборт газарт очиж, төслийн байршлын судалгааг хийж, төсөл хэрэгжих газрыг сонголоо. Хэрэгжилтийн явц: Тодорхой ахиц гарсан	70%	
	19		3. Энэ тогтоолд заасан арга хэмжээг 2024 оноос эхлэн хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, холбогдох Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт тус тус даалгасугай.	2023 оны аймгийн төсөвт Нээлттэй аймаг хөтөлбөр хэрэгжүүлэх зардалд 116.0 сая төгрөг, болон иргэдийн шилжин суурьших ая тухтай амьдрах орчин нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд Түмний хороолол болон Хаус хорооллын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын 100.0 сая төгрөгийн төсөв батлан хэрэгжүүлж байна. Мөн 2024 оны төсвийн төсөлд дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд тодорхой хэмжээний төсөв суулгахаар төлөвлөж байна.  Хэрэгжилтийн явц: Тодорхой ахиц гарсан	70%	

14	20	Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-05-03 Дугаар 2023_160	1.3. “Тахь Ресурс” ХХК-ийн өмч, хөрөнгөд халдсан асуудлыг хуулийн дагуу шалгаж, дүнг танилцуулахыг Цагдаагийн ерөнхий газар (Ж.Болд), Дундговь аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат нарт;	Аймгийн цагдаагийн газраас Сайхан-Овоо сумын нутаг Төгрөг хайрхан гэх газарт хайгуулын үйл ажиллагаа явуулж байсан “Тахь Ресурс” ХХК-ийн өмч, хөрөнгөд нутгийн иргэд халдсан асуудалд Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хэрэг бүртгэлтийн 232200002 дугаартай хэрэг бүртгэлтийн хэрэг нээн холбогдох ажиллагааг явуулж байна.	70%	
	21		2. Энэ тогтоолоор өгөгдсөн үүрэг, даалгаврын биелэлт, хэрэгжилтийн явц, тайлан, мэдээг сар бүрийн 23-ны өдрийн дотор Эдийн засаг, хөгжлийн яам, Гадаад харилцааны яаманд тус тус хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгасугай.	Монгол Улсын шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатарт аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 01/1303 дугаартай албан бичгээр “Тахь Ресурс” ХХК-ийн өмч, хөрөнгөд халдсан асуудлыг шалгаж байгаа талаарх танилцуулгыг хүргүүлсэн.Өгөгдсөн үүрэг, даалгаврын биелэлт, хэрэгжилтийн явц, тайлан, мэдээг сар бүрийн 23-ны өдрийн дотор Эдийн засаг, хөгжлийн яам, Гадаад харилцааны яаманд хүргүүлэн биелэлтийг ханган ажиллаж байна.	100%	
15	22	Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2023-06-21 Дугаар 2023_241	2. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Төрийн албаны албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан тооцоолол судалгааг гаргаж, аймгийн ИТХ-ын 2023 оны 06 сарын 27-ын өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн аймгийн 2023 оны төсөв тодотгож батлах тухай 25 дугаар тогтоолоор батлууллаа. Аймгийн засаг даргын 2023.01.16-ны өдрийн А/18 тоот захирамжаар Үйлчилгээний албан хаагчдын орон нутагт ажиллах сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн төсвөөс санхүүждэг төсвийн байгууллагын төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээг 5 хувиар	100%	

				нэмэгдүүлэн төсөвтөө багтаан олгож байна.Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн		
16	23	Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-07-05 Дугаар 2023_266	3. Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын ашиглалттай холбогдон гарах зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу жил бүрийн орон нутгийн төсөвт тусган, засвар үйлчилгээг хариуцаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Тус аймагт 2022 онд Цагаандэлгэр, Дэлгэрхангай, Эрдэнэдалай сумын сургууль цэцэрлэг дотуур байрын 9 барилга стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болсон. Өлзийт, Сайнцагаан, Гурвансайхан, Сайхан-Овоо, Эрдэнэдалай сумдын сургууль, цэцэрлэг,дотуур байрны ариун цэврийн байгууламж нь сумын нэгдсэн ариун цэврийн байгууламжтай холбогдсон. Нэгдсэн ариун цэврийн байгууламжтай холболт хийгдээгүй үлдсэн нэг байгууламж нь Сайхан-Овоо сумын цэцэрлэгийн ариун цэврийн байгууламж бөгөөд сумын нэгдсэн байгууламжид холбох ажлыг энэ онд зохион байгуулж байна. Баянжаргалан сумын сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламжид шугамын ажил хийх шаардлагагүй стандартын шаардлага хангасан. Стандартын шаардлага хангагдаагүй 8 сумын 16 объектод 2023 онд Адаацаг, Говь-Угтаал, Дэлгэрцогт, Өндөршил, Луус, Сайхан-Овоо, Хулд, Дэрэн нийт 8 сумын сургууль-5, цэцэрлэг-7, дотуур байр-4 нийт 16 барилгад стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж хийх гэрээ байгуулагдан “Сайрын харгана”, компани хийж гүйцэтгэхээр ажлаа эхлээд байна. Ажлын хүлээгдэж буй гүйцэтгэлээр аймгийн хэмжээнд 100 хувь ариун цэврийн байгууламжтай болно. Үүнээс 10-р сарын байдлаар Дэрэн сумын 3 объект 100 хувь, Луус сумын цэцэрлэг 100 хувь,Хулд, Өндөршил сумын 5 объект 20 хувийн гүйцэтгэлтэй байна.	70%	
				Хэрэгжилтийн явц: Тодорхой ахиц гарсан.		

17	24	Журам шинэчлэн батлах тухай 2023-07-19 Дугаар 2023_278	2. Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай.	Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам нь шинээр батлагдсан бөгөөд улсын төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг төлөвлөхөөс эхлэн бүх шатанд журмын хэрэгжилтийг хангуулан, батлагдсан маягтын дагуу бичиг баримтын бүрдлийг бүрдүүлэн ажиллаж байна. 10 сарын байдлаар журам зөрчигдсөн асуудал гараагүй. Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн	100%
18	25	Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2023-07-19 Дугаар 2023_279	2.. 2.5. Энэ тогтоолын хавсралтаар батлагдсан аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөц, аймгийн төвийн хүн амын хаврын улирлын махны нөөцийг бүрдүүлэх арга хэмжээ авах, отор нүүдлийг тогтоосон чиглэлийн дагуу явуулах, мал эмнэлгийн хорио цээрийн хяналт шалгалтыг эрчимжүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Аймаг, сумдын Засаг даргын аюулгүй нөөцөд өвс-394,1тн, тэжээл-164,8 тн бэлтгэж 75 хувьтай, 10 сарын байдлаар оторлолтын шилжилт хөдөлгөөн харьцангуй тогтвортой байна. Гаднын аймаг суманд тус аймгаас 69 өрхийн 48551 толгой мал, аймгийн сумд дотроо 66 өрхийн 33868 толгой мал, гаднын аймгаас тус аймагт 7 өрхийн 6262 толгой мал оторлож байна. Аймгийн төвийн жишсэн дундаж 13410 хүн амын жилийн хэрэгцээнд 587,3 тн мах хэрэгцээтэй бөгөөд 90 хоног буюу /4-6 сар/ 144,8 тн мах хэрэгцээтэй байна. Дээрх хэрэгцээнд нийлүүлэх махыг Сайнцагаан сумын махны худалдаа эрхлэгч 3 иргэн 1 аж ахуй нэгжид 10 сарын байдлаар стандартын шаардлага хангасан хөргүүрт буюу гүн хөлдөөх агуулахад 537,5 тн хонь ямааны махыг нөөцөлсөн байна.  Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн	100%
19	26	Нийслэл Улаанбаатар хотод гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гамшгийн хор	3. 3. Аймаг, сум, чөлөөт бүсийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдаагүй, тусгагдсанаас өөр зориулалтаар газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байхыг аймаг, сумын Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч нарт үүрэг болгосугай.	Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт иргэн, ААН, байгууллагад газар эзэмшүүлж, ашиглуулах шийдвэр гаргаагүй болно.  Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн	100%

		уршгийг арилгах, нийслэлийн хот төлөвлөлт, газар зохион байгуулалттай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2023-08-16 Дугаар 2023_294				
20	27	Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай 2023-08-23 Дугаар 2023_304	2. Цэргийн дүйцүүлэх алба хаах арга хэмжээг холбогдох журмын дагуу зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Цэргийн дүйцүүлэх алба хаагчдыг тус тогтоолын тооны хязгаарын дагуу цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагч 30 иргэнтэй журмыг мөрдүүлэн ажиллаж байна. Цэргийн дүйцүүлэх алба хаагчдад сургалтын арга хэмжээг журмын дагуу зохион байгуулсан. Сургалтыг 2023 оны 06,08 дугаар саруудад зохион байгуулж явуулсан. Орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа бүтээн байгуулалтын ажилд зохион байгуулалттай оролцсон.	100%	
21	28	Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2023-08-30 Дугаар 2023_312	4. Аймгийн Засаг даргын тамгын газрын орон тоог нэмэгдүүлсэнтэй холбогдон гарах зардлыг 2023 оны батлагдсан төсөвтөө багтаан зохицуулж, цаашид жил бүрийн төсвийн төсөлдөө тусгаж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай	Орон нутагт "Тогтвортой амьжиргаа-3" төсөл амжилттай хэрэгжиж, төслийн үйл ажиллагаа дуусаж байгаатай холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн бүтцэд орон нутгийн хөгжлийн сан хариуцсан мэргэжилтний орон тоо нэмэгдсэн. Үүний цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, бусад зардлын тооцоог хийж батлагдсан төсөвтөө багтаан ажиллуулах нөхцөлийг хангасан, цаашид жил бүрийн төсвийн төсөлд тусган ажиллана. Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн	100%	
	29		5. Худалдан авах ажиллагааны газар байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих журмын дагуу зохион байгуулж, албан хаагчдыг орон тоо, цалингийн сан, эд хөрөнгийн хамт Орон	Орон нутгийн өмчийн газраас Худалдан авах ажиллагааны үйл ажиллагааг салгаж газар болгож байгаатай холбоотой бүтэц, орон тоо, бусад урсгал зардлын тооцоог 2024 оны төсвийн жилээс эхлэн	30%	

			<p>нутгийн өмчийн газраас шилжүүлэн ажиллуулах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.</p>	<p>хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж тооцооллыг хийж байна.Худалдан авах ажиллагааны газрыг Орон нутгийн өмчийн газраас шилжүүлэн байгуулах тус хоёр газрын бүтэц орон тоо, албан тушаалын тодорхойлолтыг шинээр боловсруулах ажлын хэсгийг Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн А/614 тоот захирамжаар Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Л.Баярсайханаар ахлуулсан 8 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаад байна.</p> <p>Хэрэгжилт удааширсан шалтгаан: Санхүүжилтээс</p> <p>Хэрэгжилтийн явц: Тодорхой ахиц гарсан</p>		
22	30	<p>Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай 2023-08-30 Дугаар 2023_321</p>	<p>2. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг харьяалах салбар, нутаг дэвсгэртээ зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шаардагдах зардлыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын саналыг харгалзан улсын нэгдсэн төсвийн төсөлд тусган, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай.</p>	<p>Орон нутгийн иргэдийн эрүүл мэндийн боловсролын суурь түвшнийг үнэлэх судалгааны арга зүй” сэдэвт сургалтыг 60 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зохион байгууллаа. “Зүрхээ хайрлая” тэмдэглэлт өдрийн хүрээнд нийт эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагаас 375 хүнд сургалт зохион байгуулсан.</p> <p>“Таны 2 дахь гэр – Эрүүл ажлын байр” аяны хүрээнд Прокурорын газар, Сайнцагаан сумын ЗДТГ, ЭМТөв, ГХБХБГазар,1, 3 дугаар цэцэрлэгийн 68 ажилтан, албан хаагчдад “Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих, “Архи, тамхины хор нөлөө”, “Нойр ба архаг ядаргаа”, “Стресс менежмент” сэдвээр сургалтыг зохион байгуулав. Олон улсын охидын эрхийг хамгаалах өдрийн хүрээнд 212 охидод “Эрүүл зөв зохистой хооллолт”, “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” сэдвээр сургалтыг зохион байгуулсан. Medic mongolia төрийн бус байгууллагатай хамтран "Ажлаас халшрах хам шинж, Стресс менежмент" сэдэвт сургалтыг эрүүл мэндийн салбарын 47 албан хаагчид зохион байгуулав. нийт 10 сард 762 хүнийг сургалт,</p>	100%	

				мэдээллийн арга хэмжээнд хамруулан мэдлэг олгосон. Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн		
23	31	“Эрүүл шүд” арга хэмжээг хэрэгжүүлэх тухай 2023-08-30 Дугаар 2023_322	2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуульд өдөр бүр “Шүд угаах цаг”-ийг бий болгон хэвшүүлж, эрүүл ахуйн шаардлага хангасан шүдээ угаах хэсэг бий болгох ажлыг үе шаттайгаар улс, орон нутгийн төсвийн болон гадаадын зээл тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр тусгаж, холбогдох арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага өдөр бүр шүд угаах ажлыг зохион байгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Бага ангийн сурагчдыг сургууль дээр нь шүд угаах арга хэмжээг зохион байгуулах талаар нэгдсэн эмнэлэг болон ЭМГ-ын мэргэжилтэн, эмч нараас зөвлөгөө авч зөвлөгөөний үндсэн дээр Бага ангийн сурагчдыг сургууль дээр нь шүдийг нь эхний улиралд хуурай цэвэрлэгээгээр угаалгаад дараагийн улирлаас эхлэн ариун цэврийн байгууламжид угаалгах саналыг ЕБС-ийн захирлуудад танилцуулахад хичээлийн цагт зохицуулалт хийх, шүд угаах орчин нөхцөл дутмаг гэсэн тул уг арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй байна. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас Хэрэгжилтийн явц: Тодорхой ахиц гарсан	30%	
24	32	Журам батлах тухай 2023-09-13 Дугаар 2023_344	2.. 2. Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн орон нутгийн төсвийн төсөлд тусган шийдвэрлүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэхэд шаардагдах зардлыг 2024 оны орон нутгийн төсвийн төсөлд тусгахаар ажиллаж байна. Хэрэгжилтийн явц: Тодорхой ахиц гарсан	Х.Б	
<b>ЗГ-ын хуралдааны тэмдэглэл</b>						



25	33	2021 оны 3 дугаар сарын 24-ний өдөр 19 дүгээр тэмдэглэл 2021-03-24 Дугаар 2021_19	II.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй дуусаагүй, олон жил үргэлжилж, хэрэгжилт нь удааширч байгаа төсөл, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг мэргэжлийн байгууллагатай хамтран нягтлан тогтоож, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй дуусаагүй, олон жил үргэлжилж, хэрэгжилт нь удааширч байгаа Цагаандэлгэр сумын ахуй үйлчилгээний барилгын төсвийг шинэчлүүлэн үлдэгдэл санхүүжилтыг, мөн Цагаандэлгэр сумын 240 суудалтай соёлын төвийн гадна инженерийн шугам сүлжээ, Говь-Угтаал сумын спорт заалны барилгын гадна инженерийн шугам сүлжээний зураг төслийг боловсруулж тус тус 2024 оны улсын төсөвт тусгуулахаар холбогдох яамдад хүргүүлсэн байна.  Хэрэгжилт удааширсан шалтгаан: Санхүүжилтээс Хэрэгжилтийн явц: Тодорхой ахиц гарсан	30%	
26	34	2022 оны 3 дугаар сарын 2-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл 2022-03-02 Дугаар 2022_14	XIY.7.4. Мах, хүнсний ногооны нийлүүлэлт, борлуулалтад байнгын хяналт тавьж, үндэслэлгүйгээр хэт өндөр үнэ тогтоох, зохиомлоор хомсдол бий болгох, борлуулалтын хэмжээг хязгаарлах зэрэг хууль тогтоомж зөрчих явдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Б.Баасандорж), Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (Т.Гантулга), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний худалдаанд дахь нөөцийн мэдээг 7 хоног бүр сумдаас авч хүнсний нөөцөд хяналт тавьж ажиллаж байна. Аймгийн хэмжээнд гол нэрийн 12 бүтээгдэхүүний нийлүүлэлт, борлуулалт тогтвортой байна. Хүнсний худалдаа эрхлэгчдийн нөөцөд мах-1,0тн, төмс -39,0 тн, хүнсний ногоо -9.4тн байна. Шинэ хонины мах/ гулууз/ -7000-7500 төгрөгийн үнэтэй, төмс-1500-2000, хүнсний ногооны үнэ тогтвортой, нийлүүлэлт хэвийн байна.  Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн	100%	

27	35	2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл 2022-04-20 Дугаар 2022_24	ХИҮ.8.3. Хот, суурин газруудын хөгжлийн чиг хандлагыг харгалзан газрын тухай хууль тогтоомжид заасан хот, тосгон, бусад суурин, нийслэл хотын эдэлбэр газрын тэг гортигийг шинэчлэх асуудлыг судлан зохих арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Тус аймгийн хэмжээнд 2018 онд 15 сумын суурин газрын суурьшлын бүс буюу эдэлбэр газрын хил заагийг аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, 15 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд тусган батлуулсан тул тэг гортигийг дахин шинэчлэх шаардлагагүй гэсэн чиглэлийг ГЗБГЗЗГ-аас өгсөн. 2023 онд 15 сумын тэг гортигийг Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд оруулсан. Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн	100%
28	36	2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28	<p>ХХ.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав.</p> <p>Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов.</p>	<p>Аймгийн хэмжээнд 16-аас дээш насны 32044 иргэнд тоон гарын үсэг олгохоос 18 нэгжээр дамжуулан 18 иргэнд олгож 57,8 хувьтай байна. Гар утасны апп-аар 2608, 15692 иргэн иргэний үнэмлэхийн чипэнд тоон гарын үсэг авсан байна. Тоон гарын үсэг олголтыг эрчимжүүлэх, иргэдэд сурталчлан таниулах ажлын хүрээнд 10 дугаар сард ерөнхий боловсролын 2 сургууль дээр ажиллаж 70 иргэнд тоон гарын үсэг олгосон.</p> <p>Хэрэгжилтийн явц: Тодорхой ахиц гарсан</p>	70%
29	37	2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 42 дугаар тэмдэглэл 2022-08-24 Дугаар 2022_42	ХҮ.3. . Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааны явцын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав.	Эрүүл мэндийн сайдын 2022 оны 139 дүгээр тушаалаар батлагдсан “Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоо”-нд хамрагдалт бага байгаа 18-30 насны бүлгийн иргэдэд чиглэсэн мэдээлэл, сургалт	100%

			<p>Үүнтэй холбогдуулан хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод, уг үйл ажиллагаанд салбарын болон төрийн бүх шатны байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хамруулах, энэ чиглэлд салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг уриалах ажлыг зохион байгуулж зохих арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.</p>	<p>сурталчилгааг эрчимжүүлж албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийг залуучуудаа хамруулах, оюутан залуусыг орон нутагтаа урьдчилан сэргийлэх үзлэгтээ хамрагдах талаар 3 төрлийн шторк болон 4 удаагийн зөвлөмж мэдээллийг нийт 14560 иргэдэд хүргэлээ. 9 суманд цэрэг татлагын үзлэг зохион байгуулж цэргийн насны нийт 196 иргэнийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрууллаа.</p> <p>Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн</p>		
30	38	<p>2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 49 дүгээр тэмдэглэл 2022-10-10 Дугаар 2022_49</p>	<p>XII.5.2. Байгууллагын мэдээллийн системийг “Үндэсний дата төв” УТҮГ-ын үүлэн системд байршуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын удирдлагад даалгав.</p>	<p>Байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн систем ер.е өргөдөл гомдол санал хүсэлтийн цахим систем (www.7059106.mn) болон төрийн байгууллагуудын тайлан мэдээ, хяналт шинжилгээ үнэлгээний цахим системүүдийн мэдээллийг санг Үндэсний дата төв улсын төсөвт үйлдвэрийн газартай, үүлэн серверийн гэрээ байгуулан байршуулсан. Мөн аймгийн хэмжээнд төрийн архивын мэдээллийн цахим санг үндэсний дата төвийн зохиомол серверт байршуулах ажлыг зохион байгуулсан. Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн</p>	100%	
31	39	<p>2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр 54 дүгээр тэмдэглэл 2022-11-09 Дугаар 2022_54</p>	<p>X.12.2. “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 10 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлж төрийн өмчийн бүх шатны боловсролын сургалтын байгууллагын болон шинжлэх ухааны байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг батлагдсан аргачлалын дагуу үнэлүүлэх талаар шаардлагатай арга хэмжээг авч, дүнг танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Барилга, хот</p>	<p>Боловсрол, шинжлэх ухааны газар, ерөнхий боловсролын 19 сургууль, 22 цэцэрлэг буюу боловсролын салбарын 42 байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, бүртгэлд тусгасан. Аймаг, сумын Засаг даргын захирамжаар эзэмшүүлж газар эзэмших гэрээ байгуулан 2023 онд цахим гэрчилгээг Эрдэнэдалай, Дэлгэрцогт сумд дээр үүсгэсэн</p> <p>Хэрэгжилтийн явц: Тодорхой ахиц гарсан</p>	70%	

			байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.			
32	40	2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58	<p>XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:</p> <p>1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов;</p>	Цахим шилжилтийн хүрээнд аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлагууд болон сумдын Засаг даргын Тамгын газрууд 100 хувь албан бичиг солилцооны дундын систем ДОСХ-д холбогдож, бүх төрийн байгууллагуудад албан бичиг цахимаар илгээх боломжийг бүрдүүлсэн. Тоон гарын үсгээр баталгаажуулан албан бичиг боловсруулах сургалтын сум, агентлагуудын удирдлага албан хаагчдад зохион байгуулж, тоон гарын үсэг гэрчилгээжүүлэгч “тридеум кэй” компанитай гэрээ байгуулан аймаг, сумдын Засаг даргын Тамгын газруудад тоон гарын үсэг ашиглах боломжоор хангаснаар, аймгийн Засаг даргын Тамгын газар болон 15 сумын Засаг даргын Тамгын газар, 12 агентлаг тоон гарын үсэг ашиглан албан бичиг боловсруулж байна. Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний 8 агентлагуудын нийт 44 удирдах албан тушаалтнуудад албан тушаалын тоон гарын үсгийг олгож, тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим албан бичиг боловсруулан цахимаар илгээж хэвшил болоод байна.	100%	
33	41	2023 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр 2 дугаар тэмдэглэл 2023-01-05 Дугаар 2023_2	IV.2.3. хүүхдийн мөнгийг өрхийн амьжиргааны түвшинтэй уялдуулан олгох болсонтой холбогдуулан иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх чиг үүрэг бүхий хамтарсан багийг 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд аймаг, дүүрэг, сум, хороонд байгуулан ажиллуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 236-р тогтоолын дагуу хүүхдийн мөнгөн тэтгэмжийг бүх хүүхдэд олгохоор болсон. 10 сарын байдлаар аймгийн хэмжээнд 16821 хүүхдэд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгоод байна.	100%	
34	42	2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр	VIII.2.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд орон нутгийн өмчит байгууллагаас	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 4 автомашины худалдах доод үнийг	Х.Б	

		4 дүгээр тэмдэглэл 2023-01-18 Дугаар 2023_4	татан төвлөрүүлсэн автомашиныг цаашид зайлшгүй шаардлагатай байгаа орон нутгийн өмчит хуулийн этгээдэд шилжүүлэх, худалдах, актлах ажлыг зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	шинэчлэн тогтоолгохоор холбогдох материалыг хүргүүлсэн. Аймгийн иргэдийн төлөөлөгчийн хуралдахыг хүлээж байна. Хэрэгжилтийн явц: Тодорхой ахиц гарсан		
35	43	2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр 6 дугаар тэмдэглэл 2023-02-01 Дугаар 2023_6	XIY.1.3. Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулах, хянах, засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг холбогдох албан тушаалтанд хариуцуулж ажиллуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын удирдлагад;	Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн мэргэжлийн албан хаагчдын хийсэн байгалийн шинжлэлийн чиглэлээр хийгдсэн 11, Гэр бүл, хүүхэд залуучуудын газрын хүүхдийн хамгаалал хариуцсан мэргэжилтний хийсэн гэр бүлийн орчинд тулгамдаж буй асуудлын талаарх 1 нийт 12 судалгааны ажлыг sudalгаа.gov.mn нэгдсэн мэдээллийн санд байршуулж олон нийтэд хүргэж байна. Судалгааны ажлыг 2307 хүн үзэж, 914 хүн судалгааг татаж авсан ба одоогоор санал, асуулт ирүүлээгүй байна.  Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн	100%	
36	44	2023 оны 2 дугаар сарын 8-ны өдөр 8 дугаар тэмдэглэл 2023-02-08 Дугаар 2023_8	IX.2. Монгол Улсын 2022 оны төсвийн хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн батлагдсан төсвийн багцын дүнд хийсэн хөрөнгийн зохицуулалтыг Монгол Улсын 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид зарцуулах зорилгоор санхүүжилтийн зохицуулалт хийх арга хэмжээ авахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав.	Энэ онд нийт барилгын гүйцэтгэлийн ажлыг 50 хувьд хүргэхээр зорилго тавин ажиллаж байна. Сайнцагаан сумын 2 дугаар цэцэрлэгийн барилгын ажлыг “Энх баялаг констракшн” ХХК 2.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар, барилгын ажлын явц 90 хувь, Говийн Ирээдүй барилгын үлдэгдэл санхүүжилт 491.5 төгрөг батлагдаж барилгын ажил 70 хувьтай үргэлжилж байгаа, Хүмүүнлэг сургуулийн барилгын 3,2 сая төгрөг төсөвт суугдаж тус барилгын ажил 60 хувьтай хэвийн үргэлжилж байна.  Хэрэгжилтийн явц: Тодорхой ахиц гарсан	70%	
37	45	2023 оны 3 дугаар сарын 1-ний өдөр 10 дугаар тэмдэглэл 2023-03-01 Дугаар 2023_10	XVI.4.2. Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчний дэгдэлтийг таслан зогсоох мал эмнэлгийн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	10 сард малын гоц халдварт бог малын мялзан өвчин бүртгэгдээгүй. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэн дархлаажуулалтад 15 сумын 4458 өрхийн 2312446 толгой бог малыг хамруулаад байна. Гоц халдварт өвчний үед аймгийн	100%	

				засаг даргын нөөцөөс санхүүжилт гаргаагүй ба сумд хорио цээрийн дэглэмийн үед санхүүжилтийг гарган ажилласан. Дархлаажуулалтын үед Сайнцагаан, Өлзийт сумд санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажилласан		
				Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн		
38	46	2023 оны 3 дугаар сарын 07-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл2023-03-07Дугаар 2023_11	XII.5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон салбарын бодлого, стратегийн төлөвлөгөө, Жендерийн үндэсний хорооны 2023 оны ээлжит хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын жендерийн салбар зөвлөл, орон нутгийн салбар хорооны дарга, Жендерийн үндэсний хорооны гишүүдэд тус тус даалгав.	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон салбарын бодлого, стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн Жендерийн салбар зөвлөлийн Жендерийн эрх тэгш байдлыг хангах 2023 оны төлөвлөгөөг 5 зорилт, 15 арга хэмжээ бүхий төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 3 дугаар улирлын байдлаар 79.7 хувьтай байна.Засаг даргын Тамгын газраас Хүний эрхийн үндэсний комисс, Статистикийн хэлтэстэй хамтран төрийн албан хаагчийн жендерийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд төрийн 18 байгууллагын хүний нөөц, жендерийн асуудал хариуцсан 20 мэргэжилтэнд танхимаар, жендерийн дэд салбар зөвлөлийн дарга, гишүүд 70 албан хаагчид цахимаар “Жендер ба хүний эрх” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтаар Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Ажлын байрны бэлгийн дарамт, Жендерийн статистик, www.1212.mn сайт ашиглах талаар орсон ба албан хаагчид байгууллагатай тухайн сургалтыг зохион байгуулах юм. 10 сарын байдлаар 6 төрийн байгууллагаас 97 албан хаагчийг танхим, 16 албан хаагчийг цахим сургалтад хамрагдсан тайлангаа ирүүлээд байна.Хэрэгжилтийн явц: Тодорхой ахиц гарсан	70%	
	47		XII.2.1. Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо,	2023 оны 10 дугаар сард урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгт нийт 829 хүн	70%	

			<p>шинжилгээнд хамрагдалтын явц, амны хөндийн эрүүл мэндийн өнөөгийн байдлын талаар Эрүүл мэндийн сайд С.Чинзориг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:</p> <p>1.Хүн амыг эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх, аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийг дэмжих төвүүдийг ходоодны уян дурангийн аппаратаар нэмэлтээр хангахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;</p>	<p>хамрагдаж, өссөн дүнгээр нийт 19374 хүнийг хамруулж, хамрагдалтын хувь 41.0 хувь болж төлөвлөлтөд хүрсэн байна. Үүний дотор өссөн дүнгээр 0-5 насны багцад 4066(64,7%) 6-17 насны багцад 8179 (79,1%), 18 дээш насны 4 багцад 7130 (23.3%) тус тус иргэн хамрагдсан байна. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Эрүүл мэндийг дэмжих төвийн ходоодны уян дурангаар нийт 24 иргэнд дурангийн үзлэг хийж эмчилгээ зөвлөгөө өглөө.</p> <p>Хэрэгжилтийн явц: Тодорхой ахиц гарсан</p>		
39	48	2023 оны 3 дугаар сарын 22-ний өдөр 3 дугаар тэмдэглэл2023-03-22Дугаар 2023_13	<p>IV.2. Нийслэл Улаанбаатар хот, аймаг, сумын төв, бусад суурин газрын хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөлт хийгдээгүй байршилд болон иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшиж байгаа газар нь улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд өмчлүүлэхээр тусгагдаагүй газарт газар өмчлүүлэх, улсын тусгай хэрэгцээний болон бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай давхцалтай газарт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, чөлөөт бүсийн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж, хэрэгжилтэд газрын нэгдмэл сангийн цахим системээр дамжуулан хяналт тавих, газар олголтыг нээлттэй, ил тод болгох арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт даалгав.</p>	<p>Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан газрыг иргэн аж ахуйн нэгжид эзэмшүүлж, ашиглуулж, өмчлүүлж байгаа бөгөөд уг төлөвлөгөөг газрын нэгдмэл сангийн цахим системээр дамжуулан иргэдэд нээлттэй ил тод байршуулан газар олголтыг хийж байна.Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн</p>	100%	

40	49	2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр 17 дугаар тэмдэглэл 2023-04-19 Дугаар 2023_17	XIX.2.3. Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээс гаргасан шаардлага, зөвлөмжийг биелүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд болон бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгов	Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээс гаргасан шаардлага, зөвлөмж  Хэрэгжилтийн явц: Ажил огт хийгдээгүй	Х.Б	
41	50	2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр 18 дугаар тэмдэглэл 2023-04-26 Дугаар 2023_18	XIV.7.3. Ой, хээрийн түймэр, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, анхааруулгыг олон нийтэд тогтмол хүргэж, бэлэн байдлыг хангуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.	Гамшгаас урьдчилан сэргийлэх ажлаар 10 дугаар сард гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, зөвлөмж мэдээллийг олон нийтэд хүргэх зорилгоор Сайнцагаан, Хулд, Эрдэнэдалай сумын 820 өрхөд хяналт шалгалтыг зохион байгуулж гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, анхааруулгыг тогтмол хүргэж ажиллаа. 1342 зөрчил дутагдлыг илрүүлснээс хяналт шалгалтын явцад 240 зөрчлийг арилгуулж, бусад зөрчил дутагдлыг арилгуулахаар зөвлөмж өгч ажилласан. Аюулт үзэгдэл ослоос урьдчилан сэргийлэх зөвлөмж мэдээллийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан 20 удаагийн мэдээллийг цахим хуудас дагагч 7500 хүнд хүргэсэн. ОБЕГ-аас цаг агаарын сэрэмжлүүлэг шуурхай мэдээ 2 удаа хүлээн авч, орон нутгийн цаг уурын байгууллагаас тодруулан цахим хэрэглэгч 75.000 хүнд, багц мессежээр 245 хүнд, толгойн сэргийлэгч 15 малчнаар дамжуулан 92 өрхөд цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээг хүргэсэн  Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн	100%	
42	51	2023 оны 5 дугаар сарын 24-ний өдөр 22 дугаар тэмдэглэл 2023-05-24 Дугаар 2023_22	XXI.5.3. Гамшгийн улмаас хорогдсон малын сэг, зэм булшлах, устгах ажлыг шуурхай зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймгийн Засаг дарга нарт тус тус даалгав.	Аймгийн засаг даргын А/222 тоот захирамжийн хорогдсон малын сэг зэмийг устгах, халдваргүйжүүлэх ажлыг ЗДТГ-аас томилогдсон онцгой комиссын гишүүд, Мал Эмнэлгийн Тасгийн албан хаагчдын бүрэлдэхүүнтэй 51 багт үе шаттайгаар 25940 малын сэг зэм устгахаас 25293 малын сэг зэм устгалын ажлыг 100 хувь гүйцэтгэсэн.	100%	



				Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн		
43	52	Улсын төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа, удаашралтай болон үйл ажиллагаа нь зогссон барилга байгууламжийн нөхцөл байдал, шалтгаан, шийдвэрлэх арга замын талаар 2023-09-26 Дугаар 2023_39	1. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авахыг холбогдох Засгийн газрын гишүүд, барилга байгууламжийн захиалагч нарт даалгав: 1.2024 онд шилжин хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг эрчимжүүлж, гэрээт ажлын тоо хэмжээ, гүйцэтгэлийг хянаж, үнийн өсөлтийг бодитойгоор тооцож, дүгнэхийг захиалагч нарт;	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжих Сайнцагаан сумын 960 суудалтай Говийн ирээдүй цогцолбор сургуулийн барилга 80 хувьтай, Хүмүүнлэг 640 суудалтай сургуулийн барилга 40 хувьтай, Усан бассейн бүхий спорт цогцолборын барилга 45 хувьтай, Говь-Угтаал сумын 80 ортой дотуур байрны барилга 45 хувьтай, Хулд сумын ноос хяргах барилга байгууламжийн ажил 30 хувьтай тус тус үргэлжилж байна. Дээрх ажлуудад захиалагчийн хяналтыг үе шатны ажил бүрд гүйцэтгэж, үүрэг даалгавар, зөвлөмж өгч хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Санхүүжилтээс Хэрэгжилтийн явц: Тодорхой ахиц гарсан	30%	
	53		2. Хуульд заасан хугацаанд хэрэгжээгүй, 2023 онд ажлын гүйцэтгэл дутуу барилга байгууламжийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хүрээнд гүйцэтгэлийг 2023 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар дүгнэж, зайлшгүй шаардлагатай бол гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авахыг захиалагч нарт	Тус аймагт 2023 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 18 төсөл арга хэмжээнээс 2011 оноос хойш хэрэгжиж буй Төв халхын дуулалт жүжгийн театрын барилгын ажлын гүйцэтгэгч "Суурь" ХХК-тай байгуулсан барилгын угсралтын ажил гүйцэтгэх гэрээг цуцалж, дахин тендер зарласан. Эрдэнэдалай сумын төвийн 2 км хатуу хучилттай авто зам, Говь-Угтаал сумын спорт заалны барилгын асуудал ковидын улмаас шалтгаалан хийгдээгүй бөгөөд улсын төсвөөс хөрөнгө нь хасагдсан. Дэлгэрцогт сумын 250 суудалтай соёлын төвийн барилга гүйцэтгэл 90 хувьтай байгаа бөгөөд барьж байгаа компани үйл ажиллагаанаас шалтгаалан удааширч байна. Цагаандэлгэр сумын 240 суудалтай соёлын төвийн барилгын гүйцэтгэл 74 хувьтай бөгөөд гадна шугам сүлжээний хөрөнгө шийдвэрлэгдээгүйн улмаас удаашралтай үйл ажиллагаа нь зогссон байдалтай байна.	30%	

				Хэрэгжилт удааширсан шалтгаан: Санхүүжилтээс Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн		
	54		4. Зураг төсөл зохиогч, гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас хуулиар тогтоосон хугацаанд ашиглалтад оруулаагүй зохиогч, гүйцэтгэгчийн тусгай зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хүчингүй болгох арга хэмжээ авахыг тусгай зөвшөөрөл олгосон төрийн захиргааны төв байгууллагуудад, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгчийг хар жагсаалтад оруулахыг Сангийн сайд Б.Жавхланд, холбогдох мэдээллийг Сангийн яаманд хүргүүлж ажиллахыг захиалагч нарт	Тус аймагт 2021 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сайхан-Овоо сумын төвийн усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний ажлыг “Эхлэл шинэчлэлт прожект” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 53 хувьтай, 2022, 2023 онуудад ажил хийгдээгүй зогссон. Дээрх ажлын гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг цуцлуулах, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах саналыг БХБЯ-нд хүргүүлсэн.  Хэрэгжилтийн явц: Тодорхой ахиц гарсан	70%	
	55		10. Зураг төсөл нь батлагдсан, газар эзэмших, ашиглах зөвшөөрөлтэй, инженерийн дэд бүтэц нь шийдэгдсэн барилга, байгууламжийн төслийг улсын төсвөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналд тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт;	УТХО-ын 2024 оны урьдчилсан жагсаалтад төсвийн тухай хууль болон журмын дагуу шаардлага хангасан 24 шинэ барилга байгууламжийн саналыг хүргүүлсэн.  Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн	100%	
44	56	Бусад асуудал2023-10-11Дугаар 2023_41	1. Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлын асуудалд хяналт тавьж, хог хаягдалгүй, цэвэр орчин бүрдүүлэх үр дүнтэй арга хэмжээг шуурхай авч, хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	БОАЖ Сайдын 02 дугаарт албан даалгаврын хүрээнд аймгийн 15 суманд 42 удаагийн бүх нийтийн цэвэрлэгээ зохион байгуулагдаж цэвэрлэгээнд давхардсан тоогоор 4035 хүн оролцон 815,4 тн хог хаягдлыг цэвэрлэн сумдын төвлөрсөн хогийн цэгт шилжүүлсэн. Хог хаягдлаас урьдчилан сэргийлэх тухай мэдээллийг аймгийн сайтад 5, байгууллагын олон нийтийн сүлжээнд 56, байгууллагын вэб сайтад 8 удаа тус тус байршууллаа. Нийт 69 мэдээлэл оруулсан ба олон нийтийн сүлжээний цахим хандалт 4234 үзэлттэй, вэб сайтын хандалт 51206 2023 онд 10 сум ил задгай асгасан болон хогийн цэгийн 77,5 га талбайн хог хаягдлын шууж булшилсан. Аймгийн төв Сайнцагаан суманд Засаг даргын захирамжаар сар бүрийн 7 хоногийн сүүлийн баасан, бямба гаригуудад нийтийн	100%	

				их цэвэрлэгээ зохион байгуулж байна. 2023 оны 10 дугаар сард: Сайнцагаан сумын 13 шатахуун түгээх станцын 50 метр орчмын цэвэрлэгээнд хяналт хийж ангилан ялгах хогийн савны судалгаа авч шаардлага бүхий албан бичиг хүргүүлсэн. Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журмын хэрэгжилтийг хангаж ажиллах тухай албан бичгийг 15 суманд хүргүүлэв. Мандалын гэгээ хот тохижуулах газраас аймгийн төвийн бүх байгууллага, аж ахуйн нэгжүүдэд орчны хог хаягдал, цас мөсийг тогтмол цэвэрлэж байх тухай мэдэгдлийг хүргүүлсэн.Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн	
<b>ЗГ-ын албан даалгавар</b>					
45	57	Цаг үеийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх тухай2022-07-05Дугаар 2022_5	5. Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, аймаг, сумдын Засаг дарга нарт: 1.1. Улаанбаатар хот, аймаг, сумдад гэр хорооллыг хөгжүүлэх бодлогын санал боловсруулах;1.2. Гэр хороололд сургууль, цэцэрлэг байгуулах судалгаа, төлөвлөлт, хийх, гэр хорооллын иргэдэд түргэн тусламж, гал унтраах зэрэг тусламж үйлчилгээг шуурхайг хүргэх зорилгоор гудамжны орц гарцыг сайжруулах санал боловсруулах;1.3. Гэр хорооллын хог хаягдал, хөрсний бохирдол, жорлонгийн асуудлыг шийдвэрлэх, ногоон байгууламж барих, төлөвлөгөө, шийдлийг танилцуулах.	1.1. Аймаг сумдын гэр хорооллыг хөгжүүлэх бодлогын хүрээнд 10 дугаар сард дараах ажлууд хийгдсэн.-Сайнцагаан сумын 7-р багт “Түмний хороолол”,“Хаус хороолол”-ын гадна 1,8 км бохир усны шугамын ажлыг “Ашид бьютдинг” ХХК улсын төсвийн 800 сая төгрөгөөр гүйцэтгэж дууссан.- Сайнцагаан, Сайхан-Овоо, Луус сумын төвийн гэр хорооллын гэрэлтүүлгийн ажил ашиглалтад орсон.-Сайнцагаан суманд Номгон дэлгүүрийн урд талаас сургуулийн гудамж хүртэлх 280 м авто зам тохижилтын ажил ашиглалтад орсон.1.1.2 Сайнцагаан сумын 960 суудалтай Говийн ирээдүй цогцолбор сургууль, 640 суудалтай Хүмүүнлэг цогцолбор сургууль мөн Сайнцагаан, Дэлгэрцогт сумдын 150 ортой 2-р цэцэрлэгийн барилга угсралтын ажлууд графикт хугацааны дагуу үргэлжилж байна. Гэр хорооллын иргэдэд түргэн тусламж болон гал унтраах тусламж үйлчилгээг хүргэхэд гудамжны орц гарц саадгүй төлөвлөгдсөн.1.3. “Ариун цэврийн өрөөгөөр иргэд, жуулчид чөлөөтэй үйлчлүүлэх нөхцөл бүрдүүлэх тухай” аймгийн Засаг даргын	100%

				<p>2023 оны 04 сарын 21-ний өдрийн А/249 дүгээр захирамжийг төрийн болон хувийн хэвшлийн үйлчилгээний байгууллагуудад хүргүүлсэн.“Дундговьо ногооруулья” үзэсгэлэн худалдааны үеэр уг арга хэмжээний талаар 50 гаруй иргэнд сурталчилсан. “Гэрэлт ирээдүйн төлөө аюулыг авдарлая-Дундговьд” аянд 300 гаруй сурагчид 368кг аюултай хог хаягдал цуглуулсан. Мөн “Хаус хороолол”-ын гадна 1,8 км бохир усны шугамын ажлыг “Ашид бьулдинг” ХХК улсын төсвийн 800 сая төгрөгөөр гүйцэтгэж дууссанаар мандал хорооллын айлууд бохир усанд холбогдох боломжтой болсон. Гэр хорооллын 27 айл өрхийг бохир усны төвлөрсөн шугамд холбох техникийн нөхцөлийг олгосон. Аймгийн төвд 95 айл өрх стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болсон.2021 онд “Мандалговь цэцэрлэгт хүрээлэн” тохижилт ногоон байгууламжийн ажлын зураг төслийг боловсруулан хүлээлгэн өгсөн. Тус зураг төслийн дагуу 2023 оны ОНХС-ийн 1,5 тэрбум төгрөгөөр 1 дүгээр хэсгийн ажлыг “Мандал шилтгээн” ХХК хийж гүйцэтгэж байна.Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн</p>		
46	58	<p>“Шил” ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2023-04-17 Дугаар 2023_01</p>	<p>1.3.. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх захиралд тавигдах шаардлага, товч танилцуулга, ажлын туршлага, томилсон шийдвэр, цалин хөлс, урамшууллын дүн, холбогдох цахим шуудангийн хаягийн мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, “Эрдэнэс Монгол” ХХК-ны гүйцэтгэх захирал С.Наранцогт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой Дундговь Ус ОНӨААТҮГ, МАНДАЛЫН ГЭГЭЭ хот тохижуулах газар ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирлуудын товч мэдээлэл, албан тушаалын тодорхойлолт, ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл, холбоо барих дугаар, албаны цахим шуудан, томилсон шийдвэр зэрэг мэдээллүүдийг Dundgov.gov.mn аймгийн нэгдсэн сайтад байршуулж, олон нийтэд нээлттэй хүргэж байна.</p> <p>Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн</p>	100%	

	59		1.5. Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан 2008 оноос хойших шийдвэрийн талаарх мэдээллийг нэгтгэн хүргүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө-1, Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө-15, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө-15, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тодотгол-3 нийт 31 шийдвэрийн мэдээллийг ГХБХБГ-ын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 01/189 дүгээр албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.  Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн	100%	
	60		1.7. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нээлттэй мэдээллийн ил тод болгож, тайланг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгтгэж хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг эрчимжүүлэх, мэдээллийг байнга нээлттэй ил тод байлгах талаар мэдээлэл хийсэн. Мөн сум, агентлагийн ил тод байдлын асуудал хариуцаж буй Бичиг хэргийн ажилтнуудад мэдээ байршуулах заавар видеог хүргүүлж хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэл өгсөн. 98 шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийг аймгийн нэгдсэн сайт, аймгийн албан ёсны пэйж болон мэдээллийн самбарт 88,8 хувийн гүйцэтгэлтэй байршуулаад байна.Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн	100%	
47	61	Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг эрчимжүүлэх тухай 2023-07-25 Дугаар 2023_03	2.. 2. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:  2.1. Нутаг дэвсгэрийн хэмжээнд өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах талаар нарийвчилсан төлөвлөгөө, захирамж, удирдамж гарган хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих, шаардлагатай арга хэмжээг авч ажиллах;  2.2. Нийт мал сүрэгт үзлэг ангилалтын ажлыг технологийн дагуу хийж, стандартын шаардлага хангахгүй үржлийн малын 10 хүртэлх, дундаас доош тарга хүчтэй, эр сувай малын 50 хүртэлх хувийг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулах;	2.1 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах Аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 31-ны өдрийн А/459 захирамжаар төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2.2 Малд үзлэг ангилалт явуулж үржилд тэнцэхгүй, зааз малын 5%, эр сувай малын 10%-ийг эдийн засгийн эргэлтэд оруулаад байна. 2.3 Бог малын хээлтүүлэгчид үзлэг ангилалт явуулах тухай аймгийн Засаг даргын захирамж гаргуулан сумдад ажлын хэсэг томилон 2023 оны 10-р сарын 10-ны дотор багтаан нийт 23,8 мянган толгой хээлтүүлэгч малд ангилалт явуулсан. Бог мал	70%	

		<p>2.3. Хээлтүүлэгчийн үзлэг ангилалт, заазлалтыг чанартай гүйцэтгүүлэх, дутагдаж буй хээлтүүлэгчийг нөхөн тавих, хээлтүүлгийн ажлыг технологийн хугацаанд хийж хэрэгжүүлэх;</p> <p>2.4. Мал, эмнэлгийн үйлчилгээг шуурхай, чанартай зохион байгуулах, хот суурин газарт нэвтрэх мал, мах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд мал эмнэлгийн гэрчилгээ олгоходоо вакцинжуулалт, тарилга, туулгалтын хугацааг сайтар хянах, тээврийн хэрэгслийн халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, зам дагуу байрлах орон нутгийн чанартай хяналтын цэгүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх;</p> <p>2.5. Хадлангийн талбайг оновчтой хуваарилах, зохистой ашиглах, говийн бүсийн болон хадлангийн нөөц багатай аймгуудад хадлан бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах, хадлан, гар тэжээл бэлтгэх ажлыг технологит хугацаанд нь хийж гүйцэтгэх;</p> <p>2.6. Ургац хураалтад ажиллах хүн хүч, техникийн бэлэн байдал, зохион байгуулалтыг бүрэн хангуулах, цаг агаарын гамшигт үзэгдлээс ургацыг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч ажиллах;</p> <p>2.7. Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж орлого бүрдүүлэлтийг ил тод болгох, орлогын эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу эрэмбэлэн зарцуулах, хяналт тавих;</p> <p>2.8. Бэлчээрийн даац, багтаамжид тулгуурлан аймаг, сум дундын отрын бүс нутаг, улсын хилийн зурвас болон байгалийн тусгай хамгаалалттай газар нутагт отроор өвөлжүүлэх малчин өрх, мал сүргийн тоог</p>	<p>хээлтүүлгийн ажил 10 сарын 01-ээс жигдрэн явагдаж байна.</p> <p>2.5 Хадлангийн бүслүүр нутаг байхгүй тул бэлчээрийн хадлан ургадаг аймгуудаас Аймаг, сумдын Засаг даргын аюулгүй нөөц, малчид хэрэгцээний өвсийг татан бэлтгэж байна Малчид 3422 тонн гар тэжээл бэлтгэж бэлтгэл хангалт 35,8 үргэлжилж байна.</p> <p>2.6 Хадлангийн бүс нутаггүй өрхийн хэмжээнд тариалсан ургацыг хураан авч байна.</p> <p>2.7 Малын тоо толгойн албан татвараар Инженерийн хийцтэй худаг, цооног гаргах, үлийн цагаан оготнотой тэмцэх, энгийн уурхайн худаг сэргээн засварлах зэрэг ажлуудыг 563,2 сая төгрөгөөр хийж гүйцэтгээд байна.</p> <p>2.8 Аймаг дундын отрын бүс нутаг Говьсүмбэр аймгийн Малахын тал, Булган аймгийн Чилэн, Өвөрхангай аймгийн Хөхдэл отрын бүс нутгуудад 8 өрхийн 9593 тоо толгой мал оторлуулахаар захиалга хүргүүлээд байна.</p> <p>2.9 Отроор нүүдэллэж байгаа малчин өрхүүдэд тухайн сум орон нутгийн удирдлага, холбогдох албан тушаалтан, малчдад ХХААГ-ын даргын өвөлжилтийн бэлтгэл хангах 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн зөвлөмжөөр чиглэл хүргүүлэн ажилласан.</p> <p>2.10 Отор нүүдэл хийхэд харилцан тохиролцож, шаардлагатай тохиолдолд гэрээ байгуулж ажиллах чиглэл өгч ажилласан</p> <p>Хэрэгжилтийн явц: Тодорхой ахиц гарсан</p>		
--	--	---	--	--	--

		<p>харилцан тохиролцож гэрээ байгуулан ажиллах, бүс алгасаж отор нүүдэл хийхгүй байхад анхаарах;</p> <p>2.9. Отроор нүүдэллэж байгаа малчин өрхийг тухайн нутгийн захиргааны байгууллага болон хүн, мал эмнэлгийн байгууллагад бүртгүүлэх, холбогдох мэргэжлийн байгууллагын тусламж үйлчилгээ үзүүлж ажиллах;</p> <p>2.10. Орон нутгийн тусгай хэрэгцээний газарт отор нүүдэл хийх журмыг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталж, мөрдөн ажиллах;</p>		
--	--	--	--	--

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР